

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА,  
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ Г.САРАНТУЯА ТАНАА

2020.02.27 № 06/612  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Г.Сарантуяа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн балансын дансны нягтлан бодох бүртгэл, тайлагналыг холбогдох стандарт дүрэм, журмын дагуу бүртгэх, удирдлагын дээд болон дотоод хяналтыг сайжруулах талаар 2 зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “СМД аудит” ХХК-ийн аудитор Д.Гэндэнпэлжээ ахлагчтай аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/24 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан ус цаг уур, уур амьсгал, байгаль орчны судалгааны болон бодит урьдчилсан мэдээ, мэдээллээр үйлчлэхэд оршино.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ус цаг уур, уур амьсгал, байгаль орчны бодит болон ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллээр төр засаг, нийгэм, эдийн засаг, хүн амын эрэлт хэрэгцээг хангах,
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний арга зүй, технологийг боловсруулах, үйлдвэрлэлийн туршилт хийх,
- Ус цаг уур, уур амьсгал, байгаль орчин, тандан судалгаа, мэдээллийн технологийн чиглэлээр судалгаа хийх, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, технологи, төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, оролцох, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж, үнэлгээ гаргах,
- Дэлхийн ажиглалтын бүлэг, дэлхийн цаг уурын байгууллага болон бусад улс орон, олон улсын холбогдох хөтөлбөр, гэрээ, хэлэлцээртэй үйл ажиллагаа уялдуулах,
- Дэлхийн цаг уурын байгууллагын мэдээллийн сүлжээн дэх цаг уурын холбооны үндэсний төвийн үүргийг гүйцэтгэх,
- Зайнаас тандан судлах үндэсний төвийн үүргийг гүйцэтгэх,
- Байгаль орчны мэдээллийн төвийн үүргийг гүйцэтгэж, мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх,
- Орчил урсгал, урт хугацааны прогнозын судалгаа, арга зүй, технологи боловсруулах,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль,
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”,
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”,
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол,
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг Монгол Улсын Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус хүрээлэнгийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous санхүүгийн тооцоолох” програм хангамж ашигладаг байна.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 21 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 918,677.4 мянган төгрөгөөс тооцон 18,373.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,083,834.7 мянган төгрөгийн 2 хувь буюу 41,676.7 мянган төгрөгөөр тогтоосон нь тус байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, төсвийн санхүүжилтийн хэмжээ, үйл ажиллагааны орлого, зардал, эрсдэл бага байгаатай холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,542.6 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	1,548.0	55,395.1	53,847.1
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	162,076.9	159,377.9	-2,699.0
Үндсэн хөрөнгө	891,381.9	789,691.2	-101,690.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,055,006.8</b>	<b>1,004,464.2</b>	<b>-50,542.6</b>
Өр төлбөр	0.0	3,342.9	3,342.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,055,006.8	1,001,121.3	-53,885.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,055,006.8</b>	<b>1,004,464.2</b>	<b>-50,542.6</b>

Авлага дансны үлдэгдэл 53,847.1 мянган төгрөгөөр өссөн нь хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг тайлант оны эцэст улсын төсөвт төвлөрүүлэн шилжүүлснээс үүссэн татаас санхүүжилтийн авлага юм. Тайлант онд барагдах боломжгүй, он удсан авлага үүсээгүй.



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 78,288.5 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд хөрөнгө оруулалтаар 11,759.8 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 13,540.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, номын фондоос бичиг хэргийн материал руу ангилал өөрчилж бүртгэсэн 15,871.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй балансаас баланст шилжүүлсэн 23,326.1 мянган төгрөг, акталсан 64,391.8 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,001,121.3 мянган төгрөг болж тайлант оны үр дүн 53,885.5 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь тайлант онд үндсэн хөрөнгө акталсан, балансаас баланст үндсэн хөрөнгө шилжүүлснээс 31,212.1 мянган төгрөгийн гарз үүссэн, мөн үйл ажиллагааны үр дүн 22,673.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласантай холбоотой байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн нь тайлант онд 1,650.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2,255.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 36.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас орсон орлого 605.0 мянган төгрөгөөр давсан нь түрээсийн орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,292,572.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулах төсөв батлагджээ. Нийт зардлын 1,290,922.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,650.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулсан.

Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланд даатгалын үйлчилгээний зардал, нэг удаагийн мөнгөн тэтгэмжээс бусад зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хэтрэлт хэмнэлтгүй тайлагнасан байна.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн нь Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5-д заасны дагуу, Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 01/836 дугаар албан бичгээр хүргүүлсэн саналаар дамжуулан 2019 оны төсвийн зарлагын сар улирлын хуваарьтаа өөрчлөлт оруулж, нийт 3,470.3 мянган төгрөгийн зардалд зохицуулалт хийлгэсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,280,550.7 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь 1 хүний тэтгэвэрт гарах хугацаа хойшилсноос нэг удаагийн мөнгөн тэтгэмж зарцуулагдаагүйтэй холбоотой байна.

### **Нэмэлт төсөв:**

Хандив тусламжаар 12 байгууллагаас 578,557.5 мянган, гадаадын төсөл хөтөлбөрөөс 2,050.0 мянган, дээд шатны төсвийн захирагчаас 75,240.0 мянган, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,181.8 мянган, нийт 671,029.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 613,584.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 57,445.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.



## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 21 эрсдэл тодорхойлж горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 133 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 10 мэдээллийг байршуулаагүй байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг доор үзүүлэв.

#### **3.1. Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1. Илрүүлэлт:**

Авто тээврийн үндэсний төв болон, татварын бүртгэлд Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн нэр дээр бүртгэлтэй 3 тээврийн хэрэгслээс 1 тээврийн хэрэгслийг бүртгээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 –т заасан нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгийг заавал бүртгэнэ гэсэн заалтыг зөрчиж, аудитын эрх ба үүрэг, иж бүрэн байдал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.1.2. Эрсдэл:**

Тусламж, хандиваар шинээр нэмэгдсэн хөрөнгө бүртгэгдэхгүй орхигдох

##### **3.1.3. Өгсөн зөвлөмж:**

Уг тээврийн хэрэгслийг бүртгэж авах

##### **3.1.4. Байгууллагаас өгсөн харуу тайлбар:**

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Цаг уур, орчны шинжилгээний газраар дамжуулан манай байгууллагад 2019 оны 9 сард өгсөн боловч, баланст бүртгэх дансны үнийг нэгтгэсэн байдлаар 2020 онд шийдвэр гаргана гээд албан ёсоор шилжүүлж өгөөгүй тул, тээврийн хэрэгслийн улсын дугаарыг байгууллагын нэр дээр авсан боловч, санхүүгийн бүртгэлд бүртгээгүй хүлээгдэж байна. Шийдвэр ирэнгүүт бүртгэж авна.

#### **3.2. Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1. Илрүүлэлт:**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 122 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 10 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтыг зөрчиж, аудитын толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.2.2 Эрсдэл:**

Шилэн дансны тухай хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо /цаашид “шилэн данс” гэх/-г бүрдүүлэхэд оршино. Тиймээс мэдээллийг хугацаанд нь байршуулахгүй байх нь Шилэн дансны тухай хуулийн зарчмыг алдагдуулж байна.

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрч байна. Хойшид хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	163,624,891.28	214,772,997.54
33	АВЛАГА	1,548,007.01	55,395,118.92
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,548,007.01	55,395,118.92
35	БАРАА МАТЕРИАЛ	162,076,884.27	159,377,878.62
354	Хангамжийн материал	162,076,884.27	159,377,878.62
35410	Бичиг хэргийн материал	54,340,570.00	52,069,743.98
35420	Аж ахуйн материал	21,832,984.74	19,363,192.20
35430	Сэлбэг хэрэгсэл	83,984,528.44	86,615,142.44
35440	Түлш, шатах тослох материал	1.09	-
35450	Барилгын засварын материал	1,918,800.00	1,329,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	891,381,903.62	789,691,216.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	891,381,903.62	789,691,216.33
392	Биет хөрөнгө	891,264,603.76	789,652,116.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	614,852,711.40	614,852,711.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-26,732,726.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,575,250.00	66,575,250.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-65,539,687.48	-66,368,137.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,151,357,156.92	1,120,552,210.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	-914,854,457.35	-934,529,369.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	122,301,462.23	116,199,712.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-102,278,963.27	-101,833,166.87
39209	Зам, гүүрийн байгууламж	23,218,802.00	-
39210	Хуримтлагдсан элэгдэл	-21,448,801.87	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,209,833.60	935,633.60
39217	Ном	15,871,297.58	-
393	Биет бус хөрөнгө	117,299.86	39,100.02
39301	Програм хангамж	75,294,346.72	73,276,846.72
39302	Хуримтлагдсан элэгдэл	-75,177,046.86	-73,237,746.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,055,006,794.90	1,004,464,213.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	3,342,909.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,342,909.70
413	Өглөг	-	3,342,909.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	3,342,909.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,055,006,794.90	1,001,121,304.17
51	Засгийн газрын хувь оролцоо	1,055,006,794.90	1,001,121,304.17
512	Хуримтлагдсан үр дүн	588,922,571.51	535,037,080.78
51210	Өмнөх үеийн үр дүн	568,509,566.84	588,922,571.51
51220	Тайлант үеийн үр дүн	20,413,004.67	-53,885,490.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	466,084,223.39	466,084,223.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,055,006,794.90	1,004,464,213.87

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,964,484,820.14	2,029,185,740.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	114,847,070.00	56,161,501.63
120	Нийтлэг татварын бус орлого	114,847,070.00	56,161,501.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	114,847,070.00	56,161,501.63
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,650,000.00	2,255,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	113,197,070.00	53,906,501.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,849,637,750.14	1,973,024,238.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,175,192,500.00	1,290,922,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,175,192,500.00	1,290,922,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	659,547,248.14	671,029,303.45
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	566,808,748.14	578,557,485.27
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,286,000.00	75,240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,452,500.00	17,231,818.18
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,898,002.00	11,072,535.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	14,898,002.00	11,072,535.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,943,897,399.52	2,051,859,139.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,943,897,399.52	2,051,859,139.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,891,685,600.28	1,959,346,397.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,239,028,555.51	1,344,374,353.04
210101	Үндсэн цалин	998,304,698.96	1,344,374,353.04
210102	Нэмэгдэл	202,229,841.88	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,494,014.67	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,405,327.86	149,806,233.24
210201	Тэтгэврийн даатгал	118,121,303.42	107,010,828.24
210202	Тэтгэмжийн даатгал	12,955,894.42	10,809,069.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,894,084.27	8,590,939.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,948,487.07	2,126,855.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,485,558.68	21,268,542.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,604,869.00	3,477,620.00
210301	Гэрэл, цахилгаан	744,869.00	1,497,620.00
210304	Байрны түрээс	4,860,000.00	1,980,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	86,722,240.73	120,908,018.23
210401	Бичиг хэрэг	40,815,504.00	20,398,022.60
210402	Тээвэр, шатахуун	33,227,048.00	45,993,496.09
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,406,590.73	8,441,780.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,868,798.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,399,300.00	7,350,140.00
210408	Бараа материал акталсны зардал	5,000.00	38,724,579.54
2105	Нормативт зардал	1,370,800.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,370,800.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,530,636.50	57,318,605.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,282,576.00	892,800.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,250.00	-
210604	Урсгал засвар	49,246,810.50	56,425,805.00
2107	Томилолт, зочны зардал	62,426,700.00	70,052,979.80
210701	Гадаад албан томилолт	5,499,000.00	15,901,799.80
210702	Дотоод албан томилолт	56,927,700.00	54,151,180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	171,006,776.79	102,131,763.14
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	167,694,576.79	97,944,489.14
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,268,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,000.00	334,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	19,800.00	-
210807	Газрын төлбөр	352,800.00	2,352,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,589,693.89	111,276,824.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,470,080.00	14,857,595.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,119,613.89	96,419,229.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,211,799.24	92,512,741.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,940,386.00	22,440,879.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	14,898,002.00	11,072,535.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,042,384.00	11,368,344.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,271,413.24	70,071,862.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,271,413.24	70,071,862.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	20,587,420.62	-22,673,399.16
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	174,415.95	31,212,091.57
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	174,415.95	31,212,091.57
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-174,415.95	-31,212,091.57
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	20,413,004.67	-53,885,490.73

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,863,287,750.14	1,975,279,238.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,650,000.00	2,255,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,650,000.00	2,255,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,650,000.00	2,255,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,650,000.00	2,255,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,861,637,750.14	1,973,024,238.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,175,192,500.00	1,290,922,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,175,192,500.00	1,290,922,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	671,547,248.14	671,029,303.45
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	566,808,748.14	578,557,485.27
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,286,000.00	75,240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,452,500.00	17,231,818.18
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,898,002.00	11,072,535.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	14,898,002.00	11,072,535.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,828,197,850.14	1,963,519,458.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,828,197,850.14	1,963,519,458.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,774,438,043.89	1,871,006,716.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,238,974,523.46	1,323,887,652.06
210101	Үндсэн цалин	995,630,008.39	1,040,925,252.06
210102	Нэмэгдэл	204,850,500.00	183,038,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,494,015.07	99,923,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,008,100.56	165,402,017.51
210201	Тэтгэврийн даатгал	107,368,132.87	122,019,617.51
210202	Тэтгэмжийн даатгал	9,440,967.69	10,845,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,786,400.00	8,676,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,946,600.00	2,169,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,466,000.00	21,691,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,604,869.00	3,230,000.00
210301	Гэрэл, цахилгаан	744,869.00	1,250,000.00
210304	Байрны түрээс	4,860,000.00	1,980,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,184,838.73	69,819,999.00
210401	Бичиг хэрэг	13,731,400.00	8,819,200.00
210402	Тээвэр, шатахуун	32,377,048.00	48,660,704.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,418,400.00	8,428,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,657,990.73	3,911,695.00
2105	Нормативт зардал	571,800.00	358,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	571,800.00	358,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,999,460.00	69,563,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,472,740.00	10,205,220.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	128,300.00	-
210604	Урсгал засвар	48,398,420.00	59,358,380.00
2107	Томиллолт, зочны зардал	63,276,700.00	73,806,779.80



Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210701	Гадаад албан томилолт	5,499,000.00	16,779,999.80
210702	Дотоод албан томилолт	57,777,700.00	57,026,780.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	192,817,752.14	152,388,918.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	189,505,552.14	148,039,032.06
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,268,600.00	117,612.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,000.00	379,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	19,800.00	-
210807	Газрын төлбөр	352,800.00	2,352,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	12,549,350.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,549,350.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,759,806.25	92,512,741.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,940,386.00	22,440,879.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	14,898,002.00	11,072,535.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,042,384.00	11,368,344.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,819,420.25	70,071,862.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,819,420.25	70,071,862.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	35,089,900.00	11,759,780.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	35,089,900.00	11,759,780.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,089,900.00	11,759,780.00
2200	Дотоод эх үүсвэрээр	35,089,900.00	11,759,780.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,089,900.00	11,759,780.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-35,089,900.00	-11,759,780.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	568,509,566.84	568,509,566.84
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	568,509,566.84	568,509,566.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	466,084,223.39	-	466,084,223.39
Тайлант үеийн үр дүн	-	-	20,413,004.67	20,413,004.67
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	466,084,223.39	588,922,571.51	1,055,006,794.90
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	466,084,223.39	588,922,571.51	1,055,006,794.90
Тайлант үеийн үр дүн	-	-	-53,885,490.73	-53,885,490.73
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	466,084,223.39	535,037,080.78	1,001,121,304.17

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Б	1	2	3=1-2	4=2/1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,292,572,400.00	1,280,550,656.00	12,021,744.00	99.1
УРСГАЛ ЗАРДАЛ	1,292,572,400.00	1,280,550,656.00	12,021,744.00	99.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,269,182,400.00	1,269,182,312.00	88.00	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,084,556,100.00	1,084,556,100.00	-	100.0
Үндсэн цалин	801,593,700.00	801,593,700.00	-	100.0
Нэмэгдэл	183,038,600.00	183,038,600.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	99,923,800.00	99,923,800.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,569,700.00	135,569,700.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	92,187,300.00	92,187,300.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	10,845,600.00	10,845,600.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	8,676,400.00	8,676,400.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	2,169,200.00	2,169,200.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	21,691,200.00	21,691,200.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	19,051,200.00	19,051,200.00	-	100.0
Бичиг хэрэг	4,819,200.00	4,819,200.00	-	100.0
Тээвэр, шатахуун	7,416,400.00	7,416,400.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,378,400.00	5,378,400.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,437,200.00	1,437,200.00	-	100.0
Нормативт зардал	358,400.00	358,400.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	358,400.00	358,400.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	14,210,900.00	14,210,900.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	9,265,000.00	9,265,000.00	-	100.0
Урсгал засвар	4,945,900.00	4,945,900.00	-	100.0
Томилолт, зочны зардал	10,610,000.00	10,610,000.00	-	100.0
Дотоод албан томиллолт	10,610,000.00	10,610,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,826,100.00	4,826,012.00	88.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,613,700.00	2,613,700.00	-	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	117,700.00	117,612.00	88.00	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	241,900.00	241,900.00	-	100.0
Газрын төлбөр	352,800.00	352,800.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,390,000.00	11,368,344.00	12,021,656.00	48.6
Бусад урсгал шилжүүлэг	23,390,000.00	11,368,344.00	12,021,656.00	48.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,390,000.00	11,368,344.00	12,021,656.00	48.6

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,292,572,400.00	1,280,550,656.00	12,021,744.00	99.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,290,922,400.00	1,278,295,656.00	12,626,744.00	99.0
Улсын төсвөөс санхүүжих	1,290,922,400.00	1,278,295,656.00	12,626,744.00	99.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,650,000.00	2,255,000.00	-605,000.00	136.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,650,000.00	2,255,000.00	-605,000.00	136.7
АЖИЛЛАГСДЫН ТОО	98	98	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	93	93	-	100.0
Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	98	98	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	98	98	-	100.0

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		613,584,184.53
УРСГАЛ ЗАРДАЛ		613,584,184.53
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		613,584,184.53
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		239,331,552.06
Үндсэн цалин		239,331,552.06
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		29,832,317.51
Тэтгэврийн даатгал		29,832,317.51
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,230,000.00
Гэрэл, цахилгаан		1,250,000.00
Байрны түрээс		1,980,000.00
Хангамж, бараа материалын зардал		50,768,799.00
Бичиг хэрэг		4,000,000.00
Тээвэр, шатахуун		41,244,304.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,050,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,474,495.00
Эд хогшил, урсгал засварын зардал		67,112,480.00
Багаж, техник, хэрэгсэл		12,700,000.00
Урсгал засвар		54,412,480.00
Томилот, зочны зардал		63,196,779.80
Гадаад албан томилот		16,779,999.80
Дотоод албан томилот		46,416,780.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		147,562,906.06
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		145,425,332.06
Тээврийн хэрэгслийн татвар		137,574.00
Газрын төлбөр		2,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		12,549,350.10
Бараа үйлчилгээний бусад зардал		12,549,350.10
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		57,445,118.92
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		57,445,118.92
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>671,029,303.45</b>
Нэмэлт санхүүжилтийн орлого		671,029,303.45
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		578,557,485.27
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		2,050,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		75,240,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		15,181,818.18
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		<b>-</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

### 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2020.02.14</b>	Аудитын нэр: <b>Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит</b>	Аудитын код: <b>САГ-2020/181/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн</b>	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Авто тээврийн үндэсний төв болон, татварын бүртгэлд Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн нэр дээр бүртгэлтэй 3 тээврийн хэрэгслээс 1 тээврийн хэрэгслийг бүртгээгүй.	-	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Г.Сарантуяа Ч.Ганчимэг
2	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 122 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 10 мэдээллийг байршуулаагүй байна.	-	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Г.Сарантуяа Ч.Ганчимэг
<b>Нийт</b>		-			







